

**“КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕИЙН БОЛОН ШИНЭ
ХЭВИЙН НӨХЦӨЛД ОЛОН НИЙТЭД СУУРИЛСАН
НАСТНЫ ЦОГЦ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРИЙН
ЭРГЭЛТЭЭР ХҮРГЭХ ЗАМААР НЭВТРҮҮЛЭХ НЬ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН ТАЙЛАН**

**“КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕИЙН БОЛОН ШИНЭ ХЭВИЙН
НӨХЦӨЛД ОЛОН НИЙТЭД СУУРИЛСАН НАСТНЫ ЦОГЦ ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРИЙН ЭРГЭЛТЭЭР ХҮРГЭХ ЗАМААР НЭВТРҮҮЛЭХ НЬ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН ТАЙЛАН**

2020.06.26

Настанд амьдарч байгаа газарт нь олон нийтэд суурилсан настны цогц тусламж үйлчилгээг нэвтрүүлэх суурийг тавих зорилгоор Улаанбаатар хотод амьдарч байгаа эрүүл мэндийн IV, V дугаар бүлгийн настанд Коронавируст халдварын үе болон шинэ хэвийн нөхцөлд гэрийн эргэлтээр хүргэх шинэ хөтөлбөрийг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагатай хамтран монгол улсад анх удаа нэвтрүүлэх гэж байгаатай холбогдуулан энэхүү шинэ хөтөлбөрийг танилцуулах сургалтыг нийслэлийн дүүргүүдийн Эрүүл мэндийн төвийн өрхийн менежерүүд, настны кабинетийн эмч нар болон Монголын ахмадын холбооны төлөөлөл бүхий нийт 36 оролцогчтойгоор 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 11 цагаас Монголын ахмадын холбооны сургалтын танхимд зохион байгуулсан.

Сургалтын нээлтэд Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал Р. Хишигжаргал, Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар, аюулгүй байдлын албаны дарга Т. Дулмаа болон Монголын ахмадын холбооны төлөөлөл оролцсон.

Сургалт доорх баталгаажсан удирдамж, хөтөлбөрөөр явагдсан.

Сургалтын хөтөлбөр:

13:30-14:00	Бүртгэл мэдээлэл	Хариуцах албан тушаалтан
14:00-14:20	Нээлтийн үйл ажиллагаа	ДЭМБ-ын суурин төлөөлөгч <i>Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал Р. Хишигжаргал</i>
14:20-14:30	Хүндэтгэлийн зураг авахуулах үйл ажиллагаа	
14:30-15:10	Төслийн танилцуулга Эрүүл насжилт ба дэлхийн насжилтын чиг хандлага	ГҮТ-ийн ЭШСА-ны дарга Д.Болор
15:10-15:50	Хэвтрийн настанд үзүүлэх гэрийн тусламж үйлчилгээний олон мэргэжлийн багийн тусламж үйлчилгээ	ГҮТ-ийн ЭТҮА-ны дарга Ч.Одгэрэл
15:50-16:20	Настны цогц тусламж үйлчилгээ	ГҮТ-ийн ЭТҮЧАБА-ны дарга Т.Дулмаа

16:20-16:30	<i>Цайны завсарлага</i>	
16:30-17:00	Настныг нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах буюу настанд туслах сайн дурын идэвхтний үүрэг	ГҮТ-ийн нийгмийн ажилтан Ц.Сарантуяа
17:00-17.30	Коронавируст халдварын үед тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх нь	ГҮТ-ийн ЭШСА-ны мэргэжилтэн Ш.Уранчимэг
17:30-17.50	Хаалтын үйл ажиллагаа	Сургалтын баг

Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж, төгсгөлд нь дээрх хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхэд тэдний оролцоо чухал болохыг онцлон тэмдэглээд ажлын амжилт хүсэн ерөөж, зорилтот настанд хүрч хамтран ажиллахыг уриаллаа.

Зохион байгуулагчдаас Монголын ахмадын холбооны удирдлага, хамт олонд талархалаа илэрхийлсэн.

Тайланг холбогдох зургуудаар баталгаажуулав.

ТАЙЛАН БИЧСЭН:

ЭШСА-НЫ МЭРГЭЖИЛТЭН

Ш.УРАНЧИМЭГ

ХЯНАСАН:

ЭШСА-НЫ ДАРГА

Д.БОЛОР

